



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 47

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 77 дугаар зүйлийн 77.1, 77.3, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 6 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3, 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арваннэгдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Өлзийт суманд барьж ашиглалтад оруулсан 1,257,602,263 /нэг тэрбум хоёр зуун тавин долоон сая зургаан зуун хоёр мянга хоёр зуун жаран гурав/ төгрөгийн өртөг бүхий Соёлын төвийн барилга байгууламжийг Өлзийт сумын Соёлын төвийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Өлзийт сумын Соёлын төвийн дарга (Ц.Хадхүү)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;


2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Хуучин соёлын төвийн барилгын хадгалалт, хамгаалалтад байнгын хяналт тавьж ажиллах;

2.4 Энэ тогтоолын биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.ОД-ОРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн
47 дугаар тогтоолын хавсралт

Өлзийт сумын Соёлын төвийн үндсэн хөрөнгөд
бүртгэх хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Барилга байгууламж ашиглалтад оруулсан улсын комиссын актын дугаар	Хэмжих нэгж	Тоо	Дүн
1	250 хүний суудалтай Соёлын төвийн барилга	16/2021	м2	1	1,061,353,844.00
2	Дулаан цэвэр усны шугам	16/2021	м	255	51,048,218.00
3	Бохир усны шугам	16/2021	м	160	28,701,620.00
4	Цахилгааны шугам	16/2021	м	140	7,075,224.00
5	Шонтой гэрэлтүүлэг	16/2021	ш	23	28,645,847.00
6	Удирдлагатай самбар	16/2021	ш	1	5,197,335.00
7	Явган хүний зам	16/2021	м2	290	25,199,392.00
8	Бетон талбай	16/2021	м2	2550	50,380,783.00
Барилга байгууламжийн дүн					1,257,602,263.00